

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

***Үндэсний Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний
төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан***

“Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг
үүргийн хэрэгжилт, үр дүн ”

**Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс
урьдчилан сэргийлэх чиг үүргээ хэрэгжүүлж байгаа ч
гэмт хэргийн гаралт буурахгүй байна.**



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/18.

Дорноговь аймаг, Сайншанд сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.1.12, Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тоот тушаалын хавсралтын 11 “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23 дугаар зүйлийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөний дагуу “Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан болон албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн ГХУСАЗСЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга нарт тус тус зөвлөсүгэй.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга, Цагдаагийн газар, Прокурорын газарт тус тус хүргүүлсүгэй.
4. Зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер Ч.Хэрлэнчимэгт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

0825120

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Дорноговь аймгийн аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Ч.Ариунаа Аудитын менежер Ч.Хэрлэнчимэг Ахлах аудитор Ц.Лүндэгмаа Аудитор П.Энхбаяр 2017 оны 10 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7052-2734, 7052-3020 дугаарын утас, 7052-2734 дугаарын факсаар харилцана уу ХАЯГ: Орон нутгийн өмчийн 3-р байр	<i>Товчилсон үгийн тайлбар3</i> <i>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4</i> БҮЛЭГ 1 Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хуулийн дагуу зохион байгуулж байгаа боловч гэмт хэргийн гаралт буурахгүй байна. 1.1. Хууль сахиулах байгууллагууд гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцлийг тогтоох чиг үүргийг хуулийн дагуу хэрэгжүүлсэн байна.....5-6 1.2. Салбар зөвлөл, хууль сахиулах байгууллагууд гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байгаа ч ААНБ-дын оролцоо хангалтгүй байна.....7-8 1.3. Хорихоос суллагдсан хүнд дахин гэмт хэрэг үйлдэх, хэв журам зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор захиргааны хяналтыг хуулийн дагуу тогтоож байна.....8-9 1.4. Аймгийн ИТХ, Засаг даргаас ГХУС ажилд иргэн, ААНБ-уудыг татан оролцуулах ажил хийгдэж байгаа хэдий ч сум, багаас уг ажлыг зохион байгуулах ажил орхигдсон байна.....9 1.5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлж, сурталчилсан байна.....10 БҮЛЭГ 2. Салбар зөвлөлийн үйл ажиллагаа болон захиргааны хяналт тогтоох ажлууд хуулийн дагуу хийгдэж байгаа боловч иргэдийг урамшуулах, татан оролцуулах, төлбөртэй мэдээлэл авах арга хэлбэрүүд төсөв санхүүгийн хүрэлцээгүйгээс бүрэн хэрэгжихгүй байна. 2.1. Төсөв санхүүгийн хүрэлцээгүйгээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зарим арга хэлбэрийг орон нутагт хэрэгжүүлэхгүй байна.....10-11 2.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын давхардсан, орхигдуулсан чиг үүргүүд байхгүй байна.....11 2.3. Салбар зөвлөл хуульд заасан чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлж байгаа ч гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцлийг арилгахад чиглэсэн ажлыг чанаржуулах шаардлагатай байна.....11-12 БҮЛЭГ 3. 1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж үр ашгийг дээшлүүлэх хэрэгтэй байна. 3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлын төсвийг бодитой төлөвлөж, батлаагүй байна.....13-15 3.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв, санхүүжилттэй холбоотой хуулийн заалтуудыг өөрчлөх шаардлагатай байна.....15-16 3.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх, үр нөлөөг сайжруулах хэрэгтэй байна. 16-19 3.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна.....19-20 Дүгнэлт.....21 Зөвлөмж.....22 Холбогдох байгууллагын санал.....23-27 Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар.....28
---	--

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

МУ-ын ерөнхий аудиторт УАГ-аас нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөө, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон бүрэн эрхийн хүрээнд “Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит хийв.

Аудитын зорилт:

“Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийнэ.

- Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй эсэх
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж буй эсэх

Хамарсан хүрээ:

Аймаг, сумын ИТХ, ГХУСАЗСЗ, Цагдаагийн газар, Прокурор зэрэг байгууллагуудын 2015-2017 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа хамрагдлаа. Аудитыг 2017 оны 10 сарын 2-нд эхэлж 10 сарын 23-нд дуусгав.

Аргазүй:

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын аргазүйг ашиглан холбогдох байгууллагын удирдлага, мэргэжилтнүүд, санхүүгийн албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, судлах, дүн шинжилгээ болон харьцуулалт хийх, тулган баталгаажуулах зэрэг аргазүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж өглөө.

Бүлэг 1

Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хуулийн дагуу зохион байгуулж байгаа боловч гэмт хэргийн гаралт буурахгүй байна.

1.1. Хууль сахиулах байгууллагууд гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох чиг үүргээ хэрэгжүүлсэн байна.

1.1.1. Тус аймгийн хэмжээнд сүүлийн 4-н жилийн байдлаар Иргэдийн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, Иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, Тээврийн хэрэгсэл, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргүүд зонхилон үйлдэгдэж байгаа бөгөөд нийт гарсан хэргийн дийлэнх хувийг дээрх төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. *Хүснэгтээр 2014-2017 оны эхний хагас жилд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо хэмжээг хүснэгт №1-д харуулав.*

Хүснэгт №1

	2014	2015	2016	2017 II
Нийт хэрэг:	544	561	665	383
Үүнээс:	84	120	169	80
ИӨХулгай				
ИЭЧЭМЭ	196	205	221	91
ТХХАБАЖ	72	72	63	42

1.1.2. Аймгийн Прокурорын газар нь ГХУСТ хууль, Улсын Ерөнхий прокурорын тушаалаар батлагдсан “Прокурор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцох заавар”-ын дагуу 2015 онд 21, 2016 онд 11, 2017 онд 9 төрлийн ажил хийхээр төлөвлөн ажиллажээ. Тус газраас орон нутагт зонхилон үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг 2015 онд 6, 2016 онд 8, 2017 оны эхний хагас жилийн байдлаар 4 удаа судалж, дүнгийн танилцуулгыг аймаг, сумдын Засаг дарга болон ГХУСАЗСЗ-д 11 удаа хүргүүлж мэдээ мэдээллээр ханган ажилласан байна.

1.1.3. Прокурорын газар нь аймгийн хэмжээнд тодорхой төрлийн гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгааныг арилгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохиолгохоор 2015 онд 82, 2016 онд 110, 2017 оны эхний хагас жилд 71 мэдэгдэл бичиж, биелэлтийг тооцсон байна. *Хүснэгт №2-оор хяналт тавьсан хэргийн тоо, бичсэн мэдэгдлийг харуулав.*

Хүснэгт №2

Огноо	Хяналт тавьсан эрүүгийн хэргийн тоо	Шалтгаан нөхцөлийг арилгуулах мэдэгдэл	Хариу ирүүлсэн мэдэгдэл
2015	777	82	73
2016	789	110	100
2017	516	71	53

1.1.4. Прокурорын мэдэгдлийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан тухайн зөрчил, гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авч, 1 сарын дотор бичгээр хариу ирүүлэх учиртай. Гэтэл Аймгийн Прокурорын газраас бичигдсэн мэдэгдлийн хариуг зарим байгууллага, албан тушаалтан хуульд заасан хугацаанд ирүүлдэггүй байна. Тухайлбал: 2015 онд бичигдсэн 32 мэдэгдээс 5 мэдэгдлийн хариуг 2-15 хоногоор, 2016 онд бичигдсэн 39 мэдэгдлээс 13 мэдэгдлийн хариуг 2-18 хоногоор, 2017 онд бичигдсэн 27 мэдэгдлээс 2 мэдэгдлийн хариуг 3-12 хоногоор хугацаа хэтрүүлж ирүүлсэн байна. Прокурорын газар Прокурорын тухай хуулийн 36.5-д "Мэдэгдлийн хариуг хугацаанд нь ирүүлээгүй албан тушаалтанд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

1.1.5. ЦЕГ-ын "Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөөгөө"-ний дагуу орон нутагт хэрэгжүүлэх ажлыг тухайн жилүүдэд төлөвлөн хэрэгжүүлдэг байна. Гэмт хэргийн талаарх мэдээллийг цуглуулах, судалгаа дүн шинжилгээ хийх замаар түүний гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоож ажиллаж байна. Тухайлбал: "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код-307"-д заасны дагуу гэмт хэргийн мэдээлэлд 2015 онд 71 илтгэх хуудас бичсэнээс 21, 2016 онд 54 илтгэх хуудас бичсэнээс 34, 2017 оны эхний хагас жилийн байдлаар 42 илтгэх хуудас бичсэнээс 26 мэдээлэл тогтоогдож эрүүгийн хэрэг үүсгэсэн байна.

1.1.6. Цагдаагийн газрын Хэрэг бүртгэх мөрдөн байцаах тасгаас хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар мөрдөн байцаагчийн мэдэгдэл 2015 онд 223, 2016 онд 207, 2017 онд 160 бичсэн байна.

1.1.7. Хууль сахиулах байгууллагууд зонхилон үйлдэгдэж байгаа дээрх гэмт хэргийн өсч байгаа шалтгаан нөхцөлүүдэд дараах дүн шинжилгээ хийж ажилласан байна.

Бусдын бие махбодид санаатай гэмтэл учруулах, танхайрах, гэмт хэргийн шалтгаан нөхцөл: Архидан согтуурснаас, хөдөлмөрийн насны залуучууд ажиллах ажлын байргүйгээс, ажлын байртай ч цалин бага амьжиргаанд хүрэхгүй байх, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрөөх газар тэр бүр байдаггүй, хувь хүний ёс суртахуун зэрэг хүчин зүйлээс хамаарч хэсэг бүлгээрээ нийлж ахуйн хүрээнд, баар цэнгээний газар архидах, ялимгүй зүйлээс шалтгаалан хоорондоо хэрүүл маргаан үүсгэж улмаар бусдын бие махбодид санаатай болон санамсаргүйгээр гэмтэл учруулж байна. Үүнийг дагаад согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг урьд оноос 0.9 хувиар өссөн.

Тээврийн хэрэгсэл хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөл: Улаанбаатар-Замын-Үүдийн чиглэлийн босоо тэнхлэгийн авто замд жолооч нар хурд хэтрүүлэх, үзэгдэх орчин чөлөөтэй бус цаг үеэр замд гарах, согтууруулах ундаа хэрэглэсэн эсвэл хэт ядарсан үедээ тээврийн хэрэгсэл жолооддог, байнгын ажиллагаатай замын хяналтын пост байхгүй зэргээс шалтгаалан энэ төрлийн гэмт хэрэг өсөх хандлагатай байна.

Хулгайн гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцөл: Төв суурин газарт өөр аймаг, сумаас шилжин ирэгсэд өсч, хүн амын нягтаршил ихсэж байгаатай холбоотойгоор ажилгүй иргэд, амжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийн тоо нэмэгдэж орон нутагт ядуурал, байнгын орлогын эх үүсвэргүй иргэд хулгайлах гэмт хэрэг ихэвчлэн үйлдэж байна. Нийгмийн сөрөг үзэгдлүүд болон орон гэрээ удаан хугацаагаар эзэнгүй орхисноос, иргэдийг ажил албандаа явсан хойгуур хаалга, цоож, цонхыг эвдэн орж эд зүйлыг хулгайлж байгаа нь иргэдийн өөрсдийнх нь сонор сэрэмж муугаас шалтгаалж байна гэж дүгнэжээ.

1.1.8. Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судалж, орон нутгийн төр захиргааны байгууллагуудтай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шат дараатай зохион байгуулсан боловч дээрх шалтгаанууд нөлөөлсөний улмаас гэмт хэргийн гаралт төдийлөн буурахгүй байна.

1.1.9. Мөн гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа нь иргэд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан зарим эрх, үүргээ хэрэгжүүлдэггүй, иргэдийн санамсар болгоомжгүй, сонор сэрэмж муу байдагтай холбоотой байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ, хуулийн этгээд хуульд заасан зарим эрх, үүргээ хэрэгжүүлдэггүй, ажилтнууддаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах ажил хангалтгүй байна.

1.2. Салбар зөвлөл, хууль сахиулах байгууллагууд гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байгаа ч ААНБ-дын оролцоо хангалтгүй байна.

1.2.1. Нутгийн захиргааны бүх шатны байгууллагууд нутаг дэвсгэртээ гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн төлөвлөгөөтэйгээр зохион байгуулахаар хуульчлагдсан ч тус нэгдсэн төлөвлөгөө гаргаж зохион байгуулаагүй байна.

1.2.2. Бүх шатны ИТХ гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгах талаар ААНБ-аас зохиож байгаа ажлыг хэлэлцэн чиглэл өгөхөөр заасан боловч уг ажлыг хэрэгжүүлээгүй байна.

1.2.3. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-д ГХУС чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаа нь тодорхойгүй байна.

1.2.4. ХСБ-ууд ерөнхий газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу орон нутагт хэрэгжүүлэх ажлыг тухайн жилүүдэд төлөвлөн хэрэгжүүлдэг байна.

1.2.5. Тус аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй хүүхэд залуучуудын судалгаа Цагдаагийн газар, ГБХЗХГ, БСУГ зэрэг байгууллагуудад байхгүй байсан бөгөөд аудитын явцад Сайншанд сумын 4-н сургуулиас гэмт хэрэгт өртөж болзошгүй болон хараа хяналтгүй 217 хүүхдийн судалгааг ирүүлсэн байна. Тэдний зан үйлийг өөрчлөх, сургалт сурталчилгаа зохион байгуулах ажил орон нутагт хийгдэж байгаагүй байна.

Иймд гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй хүүхэд залуучуудын судалгааг тогтмол гаргуулж, тэдэнд чиглэсэн сургалт сурталчиггаа зохион байгуулах нь зүйтэй.

1.2.6. Монгол улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан СЗ хариуцан ажиллах зарим арга хэмжээг аймгийн СЗ-ийн 2017 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

- ✓ Малчин лавлах-109 таниулах, алдуул болон хулгайлагдсан малын мэдээллийн нэгдсэн сан бий болгох
- ✓ Малын түүхий эд бүтээгдэхүүний гарал үүсэлийн баталгаажилт, малын шилжилт хөдөлгөөнд хяналт хийх

- ✓ *Байгалийн ургамал түүж бэлтгэж байгаа байдалд УС хяналт шалгалт хийх, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох чиглэлээр холбогдох байгууллагын уялдааг сайжруулах*
- ✓ *Гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй хүүхэд залуучуудын судалгааг цагдаагийн байгууллагатай хамтран гаргах, зан үйлийг өөрчлөх, сургалт сурталчилгаа зохион байгуулах.*

1.2.7. ХСБ-ууд гэмт хэрэг их гарч байгаа шалтгаан нөхцөлүүдэд дүгнэлт хийж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцлийг арилгуулахад тулгамдаж буй шийдвэрлүүлвэл зохих дараах асуудлуудыг тодорхойлсон байна. Үүнд:

- Замын цагдаагийн одоо байгаа орон тоо хүн хүчээр зам тээврийн осол ихээр гарч байгаа цэгүүдийг бүрэн хяналтад авах боломжгүй тул орчин үеийн техник хэрэгслийг ашиглаж хяналт тавих асуудлыг шийдвэрлүүлэх
- Иргэдийг чирэгдүүлэхгүй байх, техникийн дэвшлийг орон нутагт нэвтрүүлэх зорилгоор бэлэн бусаар тооцох торгуулийн багажийн тоог нэмэгдүүлэх.
- Зам тээврийн ослын шалтгаан нөхцлийн судалгаанаас үзэхэд хурд хэтрүүлэн хөдөлгөөнд оролцсон гэсэн шалтгаантай осол нийт ослын 30 хувийг эзэлж байгаа учраас хурд хэмжигч багажаар хангах
- Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх цэгийн тоог цөөрүүлэх,
- Согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэргийн 53.3 хувь нь гэр орон сууцанд, 29.0 хувь нь гудамж талбайд үйлдэгдэж байгаа тул архины хамааралтай хүмүүстэй ажиллахын тулд архи хэтрүүлэн хэрэглэгч буюу архинд донтох өвчтэй хүнийг эрт илрүүлж, эмчийн хяналтад авч сэтгэл заслын нарийн мэргэжлийн эмчийн туслалцаа үзүүлэх, өрхийн эмнэлгээс үзүүлэх үйлчилгээг өргөтгөх
- Орон нутагт хэрэгжиж байгаа АА буюу сайн дурын эмчилгээнд өргөнөөр хамруулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэд, ТББ-ыг төрөөс дэмжиж хамтран ажиллах
- Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд төрийн бүх шатны байгууллага, сургууль, эцэг эх, багш, нийгмийн ажилтны ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах

Аймгийн ГХУСАЗСЗ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд тулгамдаж буй дээрх асуудлуудыг шийдвэрлүүлэх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй.

1.3. Хорихоос суллагдсан хүнд дахин гэмт хэрэг үйлдэх, хэв журам зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор захиргааны хяналтыг хуулийн дагуу тогтоож байна.

1.3.1. ГХУСТ хуулийн 15.1-д /хуучин заалт/ Эрүүгийн хуулийн 73-75, 86, 90, 111-113, 123, 125, 127, 239, 254 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт 5-аас дээш жил хорих ял эдэлсэн, эсхүл түүнийг давтан үйлдсэн хүн хорих ял эдэлж суллагдсан бол дахин гэмт хэрэг үйлдэх, хэв журам зөрчихөөс нь урьдчилан сэргийлэх зорилгоор захиргааны хяналтыг тогтооно гэж заасан байна. Хуулийн дээрх заалтын зүйл ангиудад ял эдлэх хугацаа дуусч суллагдсан иргэнээс гадна хорих ангиас хугацааны өмнө тэнсэн суллагдсан ялтай хүмүүс хамрагдах тул захиргааны хяналтыг 1-3 жил мөн шүүгчийн захирамжид заасан хугацааг дуустал тогтоодог байна.

1.3.2. Цагдаагийн газар нь давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан нийт 40 хүнд захиргааны хяналтыг хуулийн дагуу тогтоосон байна. *Цагдаагийн газрын захиргааны хяналт тогтоосон, хаасан тоо мэдээг хүснэгт №3-аар харуулав.*

Хүснэгт №3

Цагдаагийн байгууллага	2015	2016	2017
Тогтоосон	15	15	10
Шилжсэн	-	-	-
Хаасан	-	4	3
Дүн	15	11	7

1.3.3. Цагдаагийн газар дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнийг захиргааны хяналтад авах, шилжүүлэх, хаах шийдвэрийг гаргадаг бөгөөд тэнсэн суллагдсан ялтанд хяналтын хувийн хэрэг нээдэг байна. Тэдгээр хүмүүстэй ажиллах төлөвлөгөө гаргаж, сургалт зөвлөгөө, ярилцлаганд хамруулж, генетик мэдээллийн санд бүрэн хамруулсан байна.

1.3.4. Хяналтын хувийн хэргийн бүрдэл, хөтлөлтийг Прокуророор сар бүр хянуулж, байгууллагын удирдлага тухай бүр хяналт тавьж тэмдэглэл хөтөлдөг байна.

1.3.5. Хорих байгууллага суллагдах ялтны тухай мэдэгдэл, тодорхойлолтыг суллагдах хугацаанаас өмнө харьяа цагдаагийн байгууллагад 30 хоногийн өмнө хүргүүлдэггүй байна. Ихэнх тохиолдолд захиргааны хяналтад авсанаас хойш сарын дараа суллагдсан хүмүүсийн мэдэгдэл, тодорхойлолт орон нутагт ирдэг байна.

1.3.6. Захиргааны хяналт тогтоох ажил хууль журмын дагуу хийгдэж байгаа ч дээрх хяналтад байгаа иргэдийн талаарх зарим мэдээллийг цахим санд дутуу оруулсан, хорих ангиас суллагдсан иргэдийн материалын бүрдэл хангалтгүй байдаг байна. Тухайлбал: Хорих ангиас суллагдсан тухай шүүгчийн захирамж, хэргийн дугаар нь цахим сан болон ирүүлсэн материалд байдаггүйгээс дахин судлах зэргээр цаг хугацаа алдан хяналт хэрэгжүүлэхэд хүндрэл учруулдаг байна.

1.4. Аймгийн ИТХ, Засаг даргаас ГХУС ажилд иргэн, ААНБ-дыг татан оролцуулах ажил хийгдэж байгаа хэдий ч сум, багаас уг ажлыг зохион байгуулах ажил орхигдсон байна.

1.4.1. Сум, багийн нутгийн захиргааны байгууллага харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, иргэдийг татан оролцуулах ажиллагааг орхигдуулсан байна.

1.4.2. ГХУСТ хуулийн 12.3-т “Хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр ажиллуулах хүний тоо, урамшууллын хэмжээг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил тутам тогтооно” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.4.3. Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг, архины хамаарлаас гарах зорилго бүхий АА нөхөрлөлийн 12 бүлэг, давхар хамаарлын 8 бүлэг, нийт 20 бүлэг тус аймагт ажиллаж байгаа бөгөөд хорт зуршлаас ангижрах хүсэлтэй иргэдийг нөхөрлөлд холбож өгөх, олон нийтэд таниулах, сурталчлах арга хэмжээг аймгийн Зохицуулах салбар зөвлөлөөс зохион байгуулсан байна.

1.4.4. Аймгийн Засаг даргын 2017 оны А/249 дүгээр захирамжаар АА бүлгийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан ажиллах мэргэжилтний баг байгуулж, тус бүлгээр дамжуулан 300 гаруй гишүүдэд ГХУС болон архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр зөвлөгөө өгч ажилласан байна.

1.4.5. “Иргэд өөрсдийн оршин суугаа нутаг дэвсгэрийн аюулгүй амьдрах нөхцлийг бүрдүүлэх, ахуйн хүрээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдэж, энэ чиглэлээр нутгийн захиргааны байгууллага болон цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах тогтолцоог бүрдүүлэх” зорилго бүхий “Хөршийн хяналт” хөтөлбөрийг аймгийн ИТХТ-ийн 2017 оны 57 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна.

1.4.6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд сурагчдын эцэг эхийг татан оруулах зорилгоор “SCHOOL POLICE” эргүүлийг 2015 оноос эхлэн ажиллуулж хэвшсэн байна.

1.5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлж, сурталчилсан байна.

1.5.1. МУГХУСА33-ийн 2017 оны 7/1981 албан бичгийн дагуу “Сэргийлэгч” нэвтрүүлэг болон тус зөвлөлийн цахим хуудсанд байрлах шторкнуудыг www.cccp.mn сайтаас татан авч орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон салбар зөвлөлийн “Дорноговь аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл” фэйсбүүк page хуудсаар дамжуулан давтамжтайгаар иргэдэд хүргүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

1.5.2. Аймгийн Салбар зөвлөлөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийн талаар болон зөвлөлөөс зохион байгуулсан ажлын тайланг жил бүр иргэдэд мэдээлэн, зөвлөгөө өгч, шинээр гарсан хууль тогтоомжийг таниулах, сурталчлах зорилгоор гарын авлага материал тарааж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сурталчилдаг байна.

1.5.3. ХСБ-ууд чиг үүргийнхээ дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулдаг байна.

Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн

Бүлэг 2

Салбар зөвлөлийн үйл ажиллагаа болон захиргааны хяналт тогтоох ажлууд хуулийн дагуу хийгдэж байгаа боловч иргэдийг урамшуулах, татан оролцуулах, төлбөртэй мэдээлэл авах арга хэлбэрүүд төсөв санхүүгийн хүрэлцээгүйгээс бүрэн хэрэгжихгүй байна.

2.1. Төсөв санхүүгийн хүрэлцээгүйгээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зарим арга хэлбэрийг орон нутагт бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

2.1.1. ГУСТ хуулийн 3 дугаар бүлэгт урьдчилан сэргийлэх ажлыг дараах арга хэлбэрээр хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулах
- Гэмт хэргийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах
- Хорих ял эдлээд суллагдсан хүнд захиргааны хяналт тогтоох
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл ажиллуулах

2.1.2. Нутгийн захиргааны байгууллага харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахдаа иргэдийг татан оролцуулах ажиллагаа хангалтгүй байна.

2.1.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, байгууллагыг төсөв санхүүгийн хүндрэлээс шалтгаалан 2015-2017 онуудад орон нутагт 10 гаруй иргэнийг мөнгөн шагналаар урамшуулсан байна.

2.1.3. Иргэдээс гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн тухай мэдээллийг төлбөртэй авах урьдчилан сэргийлэх арга хэлбэр нь санхүүгийн нөөцгүйгээс хэрэгжихгүй байна.

2.1.4. Хорихоос суллагдсан хүнд дахин гэмт хэрэг үйлдэх, нийгмийн хэв журам зөрчихөөс нь урьдчилан сэргийлэх зорилгоор захиргааны хяналт тогтоож байгаа арга хэлбэр нь хууль журмын дагуу хийгдэж байгаа ч цахим мэдээллийн санд мэдээлэл дутуу байдаг тул захиргааны хяналт тогтооход дахин судалгаа, мэдээлэл олж авах зэргээр цаг хугацаа алдах зэргээр орон нутагт захиргааны хяналтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг байна.

2.1.5. Аймгийн Зохицуулах зөвлөл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хуулийн дагуу зохион байгуулж байна. Үүнээс гадна ГХУС үйл ажиллагаатай холбоотой тулгамдсан асуудлыг тухай бүр хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

2.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын давхардсан, орхигдуулсан чиг үүрэг байхгүй байна.

2.2.1. ГХУСТ хуулийн 7.6.1-д Нутгийн захиргааны бүх шатны байгууллага харьяа нутаг дэвсгэртээ гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах гэсэн заалтыг хэрэгжүүлдэггүй байна. Аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нар ГХУСАЗСЗ-ийн дарга, орлогч даргаар ажилладаг тул салбар зөвлөлийн төлөвлөгөөгөөр хариуцуулсан ажлыг тухайн жилд аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж, аймгийн ИТХ-д тайлангаа хагас бүтэн жилээр тайлагнадаг учир Засаг дарга ГХУСА-ын нэгдсэн төлөвлөгөө боловсруулаагүй гэсэн тайлбар ирүүлсэн байна.

2.2.2. ГХУСТ Хуулийн 7.7-д "Бүх шатны ИТХ нь тухайн нутаг дэвсгэр дээр гарч байгаа гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар харьяа нутаг дэвсгэрт оршиж байгаа ААНБ-аас зохиож байгаа ажлыг хэлэлцэн чиглэл өгнө" гэж заасныг орон нутагт хэрэгжүүлж ажилладаггүй байна.

2.2.3. ГХУСА-д төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, ГХУС үйл ажиллагааны цар хүрээг тэлэх зорилгоор аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2016 оны 34 дүгээр тогтоолоор зөвлөлийн бүрэлдэхүүнд Эрүүл мэндийн газар, Боловсрол соёл урлагын газрын дарга нарыг нэмж оруулсан байна.

2.2.4. Салбар зөвлөлийн гишүүд ГХУСА-ыг өөрсдийн харьяа байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагаанд уялдуулан зохион байгуулж, зөвлөлийн хурлаар шийдвэрлэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтын болон сурталчилгааны хяналт шалгалтын зэрэг ажлуудыг хамтарч зохион байгуулж байна.

2.3. Салбар зөвлөл хуульд заасан чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлж байгаа ч гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн ажлыг чанаржуулах шаардлагатай байна.

2.3.1. Аймгийн ИТХ-ын 2009 оны 08 дугаар тогтоолоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн гишүүдийн ажиллах журмыг баталж, аймгийн хэмжээнд дэг журам бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын явц болон хөтөлбөрүүдийн биелэлтийг жил бүр дүгнэн танилцуулж байхыг Зохицуулах зөвлөлд даалгасан байна.

2.3.2. Аймгийн ГХУСАЗСЗ-өөс 2015 онд 4 чиглэлээр 34 ажил хийхээр төлөвлөсөн хэдий ч төлөвлөгөөнд тусгагдсан ажлын ихэнх нь хийгдсэн эсэх тодорхойгүй, тухайн жилийн ажлын тайланд тусгагдаагүй байна. Тухайлбал :

- Сумдын салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөөний биелэлтийг тайлангаар авч дүгнэх,
- Аймгийн хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт хийж цаашид авах арга хэмжээний талаар бодлогод тусгах,
- Зөвлөлийн гишүүд болон хууль сахиулах байгууллагуудын хоорондын мэдээллийг сайжруулах,
- Байгаль орчныг хамгаалах чиглэлээр бодлого баримтлах
- Хорих ял эдэлж байгаа болон цагдаагийн хорих байранд хоригдож байгаа сэжигтэн, яллагдагчдад тавих хяналтыг сайжруулах
- Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, таслан сэргийлэх бодлого баримтлах
- Шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр сургалт зохион байгуулах
- Терроризмоос урьдчилан сэргийлэх үүднээс тэсэрч дэлбэрэх бодис бүхий онцгой объектуудад тавих хяналтыг сайжруулах

2.3.3. Аймгийн Зохицуулах зөвлөл 2015 онд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын явц болон хөтөлбөрүүдийн биелэлтийг аймгийн ИТХ-д тайлагнаж ажиллаагүй байна.

2.3.4. Аймгийн ИТХ-ын 2016 оны 33 дугаар тогтоолоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн салбар зөвлөлийн ажиллах журмыг, 2016 оны 34 дүгээр тогтоол, 2017 оны 26 дугаар тогтоолоор салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

2.3.5. Аймгийн ГХУСАЗСЗ-өөс 2016 онд 4 чиглэлээр 27 ажил хийхээр төлөвлөсний 23 ажил нь урьд оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хуулбарласан бөгөөд тайлант онд хийгдэх ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулан тайлагнасан байна.

2.3.6. Аймгийн ГХУСАЗСЗ урьд оны тайланг авч хэлэлцэн дүгнэж, анхаарах асуудлаа тодорхойлон 2017 онд 4 чиглэлээр 40 зүйл заалт бүхий төлөвлөгөөг МУГХУСАЗЗ-ийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, эхний хагас жилийн байдлаар иргэдийн санал бодлыг сонсох, гаргасан санал хүсэлтийн дагуу холбогдох ажлыг шат дараатай хэрэгжүүлэх зэргээр ГХУСА-ыг зохион байгуулсан байна.

2.3.7. Салбар зөвлөл нь гэмт хэргийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт хийж байгаа хэдий ч шалтгаан нөхцөлийг арилгуулах чиглэлээр хийсэн арга хэмжээ хангалтгүй байна.

2.3.8. МУ-ын Ерөнхийлөгчийн 2001 оны 25 дугаар зарилгын 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журмын 2.12-т “Аймаг, нийслэлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдний ажлыг шалган зааварлаж, чиглэл өгөх” гэж заасны дагуу тус зөвлөлөөс аймгийн ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлыг шалган заавар чиглэл өгч байгаагүй байна.

Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр лүн

Бүлэг 3

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж үр ашгийг дээшлүүлэх хэрэгтэй байна.

3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлын төсвийг бодитой төлөвлөж, батлаагүй байна.

3.1.1. Аймгийн ИТХ-ын ажлын албанаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлын төсвийг боловсруулдаг байна. Боловсруулж хүргүүлсэн төсвийн санал, батлагдсан төсвийг хүснэгт №4-т харуулав.

Хүснэгт №4	сая төгрөгөөр		
	Боловсруулсан санал АИТХ	Батлагдсан төсөв АИТХ	Батлагдсан төсөв СИТХ
2015 он	34.4	70.4	4.0
2016 он	147.6	59.4	4.2
2017 он	125.4	58.8	18.9

3.1.2. Аймгийн ИТХ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын сүүлийн 3 жилийн төсвийн төсөөллийг боловсруулахдаа үйл ажиллагааныхаа төлөвлөгөөтэй уялдуулж зардлаа тооцоогүй, өөрөөр хэлбэл гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөлийн судалгаанд үндэслэн тухайн тайлант онд зохион байгуулах ажлын чиглэл тус бүрт зарцуулагдах зардлын мөнгөн дүнг тооцоогүй байна.

3.1.3. Сангийн яамнаас төсвийн төсөлд тусгагдсан хэмжээгээр бус өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төсвийг хянадаг ба аймгийн ИТХ сангийн яамнаас хянасан дүнг бага хэмжээгээр нэмэгдүүлэн ГХУСҮАЗ-ын төсвийг баталсан байна.

3.1.4. Сумдын гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн гаралтыг харгалзан үзэж төсөв батлаагүй байна. 2015, 2016 онуудад сумдын ИТХ-д ГХУСЗ-ын төсөв батлагдаагүй бөгөөд 2017 онд сум тус бүрт 1.0 сая төгрөг буюу 14.0 сая төгрөг баталсан байна.

3.1.5. Сумын ИТХ-аас ГХУСҮА-ны зардалд төсөв баталсан 2 сум байна.

	2015 он	2016 он	2017 он
Замын-Үүд сум	3.0	4.0	4.9
Хатанбулаг сум	1.0	0.2	-
Дүн	4.0	4.2	4.9

3.1.6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.1-д “Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан.

Батлагдсан төсөв нь Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газруудаас оруулсан хүү торгуулийн орлогын дүнгийн 40 хувиар тооцогдож батлагдаагүй байна. Тухайлбал: 2016 онд 75.8 сая төгрөгөөр батлах байтал 63.6 сая төгрөгөөр буюу орлогын 33.5 хувиар, 2017 онд 149.4 сая төгрөгөөр батлах байтал 77.7 сая төгрөгөөр буюу орлогын 20.8 хувиар тус тус ГХУСҮА-ны зардлын төсөв батлагдсан байна.

Орон нутгийн төсөвт орсон хүү торгуулийн орлогын дүнг Хүснэгт № 5-аар харуулав.

Хүснэгт №5		сая төгрөгөөр		
	Байгууллагын нэр	2015 он	2016 он	2017 оны эхний хагас жил
1	Замын-Үүд сумын Цагдаагийн хэлтэс	64.2	180.3	70.9
2	Цагдаагийн газар	117.0	189.6	178.7
3	ШШГГазар	8.4	3.5	3.0
	Орлогын дүн	189.6	373.4	252.6
	40% -иар тооцсон дүн	75.8	149.4	
	Батлагдсан зардлын төсөв	74.4	63.6	77.7
	Орлогын дүнд эзлэх хувь		33.5	20.8

3.1.7. ГХУСҮА-ны зардлын төсвийг бодитой төлөвлөж, батлаагүйгээс Цагдаагийн байгууллагын ГХУС үйл ажиллагаанд шаардлагатай техник хэрэгсэл авах, ажлын байрны өргөтгөлийн засвар, тавилга эд хогшил авах, замын хөдөлгөөний мэдлэг олгох тэмцээнд зориулсан хөрөнгийг бусад эх үүсвэрээс шийдвэрлэсэн байна. Тухайлбал:

- Аймгийн Цагдаагийн газарт 2017 онд: Сайншанд сумын ЗД-ын нөөц хөрөнгөнөөс Хамарын хийдэд 24 цагаар ажиллах цагдаагийн байрны засварт 508.0 мянган төгрөг, АИТХ-ын нөөц хөрөнгөнөөс 1.0 сая төгрөгөөр Замын хөдөлгөөний цагаан толгой 2017 тэмцээнд, Аймгийн ЗД-ын захирамжаар орон нутгийн төсвийн чөлөөт үлдэгдлээс 23.0 сая төгрөгийн замын цагдаагийн эргүүлийн 2 машины үнэ шийджээ. Зураг №1-д харуулав.



Зураг №1

- Замын-Үүд сумын Цагдаагийн хэлтэст Замын-Үүд сумын Засаг даргын 2015 оны захирамжаар Замын-Үүд сангаас мобайл компьютер торгуулийн машин 22687.5 мянган төгрөгөөр, 2016 онд Замын-Үүд сумын Засаг даргын захирамжаар сумын төсвийн хөрөнгө оруулалтын зардлаар нисдэг камер 6.5 сая төгрөгөөр, Цагдаагийн хэлтсийн барилгын өргөтгөлийн засварын ажилд 6.0 сая төгрөгөөр, өрөөний тохижилтын зардалд тавилга хэрэгсэл 4.0 сая төгрөг, /зураг №3/ 2017 онд Сумын ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалтын зардлаас хэлтсийн байрны засварт 15.0 сая төгрөг тус тус зарцуулсан байна.
- Айраг сумын ГХУС салбар зөвлөл 2015 онд ГХУС сантай байсан бөгөөд тус сангаас сургалт сурталчилгааны зардалд 2015, 2016 онд 0.7 сая төгрөг, АА бүлгийн үйл ажиллагааг дэмжиж 0.2 сая төгрөг зарцуулж тус санг 2016 онд хаасан байна.

3.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв, санхүүжилттэй холбоотой хуулийн заалтуудыг өөрчлөх шаардлагатай байна.

3.2.1. ГХУС тухай хуулийн 19.1 дэх заалт нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т “Санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” гэсэн зарчимтай нийцэхгүй байна. Тухайлбал: ГХУС зардлыг хүү торгуулийн орлогын 40 хувиар тооцоход 2016 онд 75.8 сая төгрөг, 2017 онд 149.4 сая төгрөгөөр төсөв батлахаар байгаагаас харахад жил бүр харилцан адилгүй төсөв батлагдах болж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.7-д “төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр арга хэмжээ, ... тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2. МУ-ын хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 1998 оны 88/152 тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын ГХУС арга хэмжээнд зориулах зардлын төлөвлөлт, гүйлгээний баримтанд гарын үсэг зурах тухай, хөрөнгийн үлдэгдлийг дараагийн жилд зарцуулах эсэхийг шийдвэрлэх заалтууд Төсвийн тухай хуультай нийцэхгүй байна.

3.2.3. МУ-ын Цагдаагийн албаны тухай хуулийн 24.9-д “Олон нийтийн цагдаагийн ажилтны таних тэмдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцас, нэг бүрийн тусгай хэрэгсэл, урамшил, сургалт явуулахтай холбогдсон зардлыг тухайн шатны Засаг дарга гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлнэ” гэж заасан байдаг. ГХУС үйл ажиллагааны зардлын төсөв нь ИТХ-ын үйл ажиллагааны төсөвт тусгагдан батлагддаг бөгөөд шат шатны Засаг даргын захиран зарцуулах төсөвт энэхүү зардлын төсвийг баталдаггүй. Хуулиудын ойлгомжгүй, нийцэхгүй заалтуудаас шалтгаалж ОНЦ-ийн хувцас хэрэгслийн зардлыг аль ч байгууллагын төсөвт тусгаагүй байна.

- Аймгийн Засаг даргын 2013 оны А/701 тоот захирамжаар ОНЦ-ийн ажилтны таних тэмдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцас, хэрэгсэл авахад 41.4 сая төгрөгийг аймгийн орон нутгийн төсвийн чөлөөт үлдэгдлээс санхүүжүүлж шийдвэрлэсэн бөгөөд одоог хүртэл дахин хувцас хэрэгсэл аваагүй байна.
- ОНЦ-ийн ажилтан ажлаас чөлөөлөгдөхөд хувцас, хэрэгслийг хураан авч элэгдлийн дүнгээр тооцоо хийж ажилтнаар төлүүлдэг ба томилогдсон ажилтанд өмнөх ажилтны хувцас, хэрэгслийг хүлээлгэн өгдөг байна.

3.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх, үр нөлөөг сайжруулах хэрэгтэй байна.

3.3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардалд 2015 онд 71.6 сая төгрөг зарцуулж 2.8 сая төгрөгийн төсвийн хэмнэлт, 2016 онд 63.3 сая төгрөг зарцуулж 0.3 сая төгрөгийн хэмнэлт гаргасан ба 2017 оны эхний хагас жилд 37.9 сая төгрөг зарцуулж хүлээгдэж байгаа гүйцэтгэл 39.8 сая төгрөг байна. Төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгт №6-д харуулав.

Хүснэгт №6		сая.төг					
		2015 он		2016 он		2017 он	
		Төл-өө	Гүй-гэл	Төл-өө	Гүй-гэл	Төл-өө	Гүй-гэл
	АИТХ	70.4	69.8	59.4	59.1	58.8	34.1
	СИТХ	4.0	1.8	4.2	4.2	18.9	3.8
	Дүн	74.4	71.6	63.6	63.3	77.7	37.9

3.3.2. ГХУС ажилд зориулан батлагдсан хөрөнгийг ГХУСАЗСЗ дараах зориулалтаар зарцуулсныг хүснэгт №7-д харуулав.

Хүснэгт №7		сая төгрөгөөр		
	Зардлын төрөл	2015 он	2016 он	2017 он
1.	ГХУС талаар сургалт сурталчилгааны зардал	7.9	14.9	3.8
2.	Олон нийтийн цагдаагийн урамшуулал	60.2	36.3	32.0
3.	ГХУС ажилд идэвхитэй оролцсон иргэдийг шагнаж урамшуулах	1.0	0.2	0.4
4.	Тэтгэвэр тэтгэмжийн зөрүү, зардал нөхөн төлбөрийг төлөх	-	-	-
5.	Цагдаагийн байгууллагын ГХУС үйл ажиллагаанд шаардлагатай техник хэрэгслийн зардлыг санхүүжүүлэх	1.9	4.7	-
6.	Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн тухай цагдаагийн байгууллага иргэдээс мэдээлэл авах төлбөрийн зардлыг санхүүжүүлэх	-	-	-
7.	Бусад		0.5	1.2
8.	Зориулалт бусаар зарцуулсан зардал	0.6	6.7	0.5
	Дүн	71.6	63.3	37.9

3.3.3. *ГХУС сурталчилгааны зардал*: Нийт зардлын 10 гаруй хувийг ГХУСАЗСЗ-өөс сумдад ажиллах гишүүдийн томилолт, шатахууны зардал, тараах материал, үзүүлэнгийн самбар, хаяг, гарын авлага, тараах материал хэвлүүлэх, түүнд зарцуулах бичгийн цаас, принтерийн хор авах, сургагч багшийн хөлс, хоолны үнэ, зар мэдээ болон нэвтрүүлэг, сурталчилгааны хөлс, хууль сурталчлах АХА, Дэвжээ тэмцээн, уралдааны шагналд зарцуулагдсан байна. Тухайлбал:

- АИТХ-аас 2016 оны 12 сард ГХУС сургалт сурталчилгааны самбаруудад байршуулах зураг, тараах материалын үнэ гэж 5.2 сая төгрөгийг хувь хүний дансанд шилжүүлсэн бөгөөд эд хариуцагч бараа материалын тайланд үнийн дүнгээр орлого авч үлдэгдэлтэйгээр тайлагнасан байв. 2017 онд тухайн хүнд захиалга өгч тараах материал, бусад зүйлийг хүлээн авч тооцоо дуусгажээ.
- ГХУСАЗСЗ-ийн тогтоолын дагуу шатахуун түгээх байгууллагуудад ГХУС ажилд зарцуулагдах шатахууны үнийг бөөн дүнгээр шилжүүлсэн бөгөөд эд хариуцагчийн тайланд зарцуулалтын анхан шатны баримт материалыг бүрэн хавсаргаж архивлаагүй, /Замын-Үүд сумын ИТХ/ аудитын явцад үдэгдээгүй 2.1 сая төгрөгийн баримт ирүүлж байв.

Дээрх ажил гүйлгээнүүдэд НББ-ийн “үнэн зөв байх” зарчим алдагдаж НББ-ийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж байна.

- Тус зардлын төсвөөс ИТХ Тахарын албанд 2016 онд 1400.0 мянган төгрөгийг Тахар хүү иж бүрэн өмсгөл авахад олгосон ба одоо уг хувцаснууд ямар ч ашиглалтгүй агуулахад хадгалагдаж байна. Мөн тус хувцасыг зах зээлийн үнээс өндөр үнээр авсан байв. Өмд 70.0, гутал 130.0, дээл бүс 260, толгойн баг 610.0, даалин 45.0, ташуур 25.0, хантааз 260.0 мянган төгрөгийн үнэтэй байна.

3.3.4. *Олон нийтийн цагдаагийн урамшуулал*: ОНЦ-ийн урамшуулалд 2015, 2017 онуудад нийт төсвийн 80 гаруй хувийг, 2016 онд батлагдсан орон тооноос 11-ээр дутуу ажилласан тул 60 гаруй хувийг зарцуулжээ. Сумын Засаг даргын санал, иргэд өөрсдийн хүсэлтээр Цагдаагийн газраас зохион байгуулж буй ОНЦ-ийн ажилтны танхимын болон дадлагын сургалтанд хамрагдаж шалгалтанд тэнцсэн иргэдийг ОНЦ-аар ажиллуулдаг байна.

- Цагдаагийн урамшууллыг сумын ЗДТГ-т шилжүүлдэг ба гүйцэтгэсэн ажлын тайлан, цагийн баланс бүртгэл тооцоо, томилогдсон болон чөлөөлөгдсөн тушаал шийдвэрийг холбогдох байгууллагуудаас хүлээн аваагүй, сумдын ЗДТГ-тай урамшуулалд олгосон санхүүжилтийн тооцоог хийгээгүй байна.

3.3.5. *ГХУС ажилд идэвхитэй оролцсон иргэдийг шагнаж урамшуулах*: Аймаг сумын ГХУСАЗСЗ-өөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдэд баг хамт олноо төлөөлж идэвхитэй оролцсон 10 гаруй иргэдэд 2015-2017 онуудад 1.6 сая төгрөгийн шагнал урамшуулал олгож хувь хүний албан татвар суутган шилжүүлсэн байна.

3.3.6. *Тэтгэвэр тэтгэмжийн зөрүү, зардал нөхөн төлбөрийг төлөх*: Энэ төрөлд зардал гаргаагүй байна.

3.3.7. *Цагдаагийн байгууллагын ГХУС үйл ажиллагаанд шаардлагатай техник хэрэгслийн зардлыг санхүүжүүлэх*: Аймгийн салбар зөвлөлөөс 2015 онд Замын-Үүд сумын Цагдаагийн хэлтэст 1171.8 мянган төгрөгийн гар станц, дахин дамжуулах суурин станц, 2016 онд аймгийн Цагдаагийн газарт 2150.0 мянган төгрөгийн дуудлага хүлээн авагч компьютерийг, Замын-Үүд дэх салбар зөвлөл Замын-Үүдийн Цагдаагийн хэлтэст 2015 онд жижүүр, эргүүлийн ажлын хэрэгцээнд хантааз, малгай, дохиур, шүгэл авахад зориулж 700.0 мянган төгрөг, 2016 онд ОНЦ-ийн ажилтнуудад компьютер, принтер, нягтаршил ихтэй газруудад гэрэл дохион авахад 2.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Эдгээр хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгасан байв.

3.3.8. *Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн тухай цагдаагийн байгууллага иргэдээс мэдээлэл авах төлбөрийн зардлыг санхүүжүүлэх*: Энэ төрөлд хөрөнгө мөнгө зарцуулаагүй байна.

3.3.9. *Бусад*: Аймгийн 9 суманд “Архичид аминчлахуй” бүлэг бий болж архинаас татгалзаж байгаа үйл ажиллагааг сум орон нутгийн ГХУС салбар зөвлөлүүд дэмжиж 2015-2017 онуудад 1.1 сая төгрөгийн урамшуулал олгосон байна. Мөн Замын-Үүд сумын ИТХ 2017 оны 1-р улиралд ОНЦ-ийн урамшууллын суутган тооцсон татвар, НДШ-ийн зардал 577.5 мянган төгрөгийг ГХУСҮА-ны зардлаас шилжүүлсэн байна.

3.3.10. *Зориулалт бусаар зарцуулсан зардал:* ГХУС үйл ажиллагаанд зориулсан хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулах тогтоол шийдвэр гаргаж 2015 онд 626.3 мянган төгрөг, 2016 онд 6628.9 мянган төгрөг, 2017 оны эхний хагас жилд 656.0 мянган төгрөг зарцуулсан байна.

ГХУСАЗСЗ-ийн гишүүд, байгууллагаас сум орон нутагт хууль, эрхзүйн чиглэлээр үзлэг, шалгалт, сургалт сурталчилгаа хийхэд хоолны зардал гаргах, зориулалт бус шагнал, урамшуулал, өдөрлөгийн арга хэмжээ, тээврийн зардалд ГХУСЗ-ын төсвөөс мөнгө олгосон байна.

- Замын-Үүд сумын ИТХ-ын даргын захирамжаар ГХУСАЗСЗ-ийн гишүүдээс сургалт сурталчилгаа зохион байгуулах үеийн хоолны зардалд 2016-2017 онд 1008.3 мянган төгрөг, нээлттэй хаалганы өдөрлөгийн зардалд 128.5 мянган төгрөг
- Эрдэнэ сумын ИТХТ-ийн тогтоолоор 2017 онд 206.2 мянган төгрөгийн хоолны зардал
- Айраг сумын ИТХТ-ийн тогтоолоор 2017 онд сумын “Хүндэт иргэн”-ний дагалдах мөнгөн шагналд 50.0 мянган төгрөг
- Аймгийн ИТХ 2015, 2016 онуудад цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах ажлын урамшууллын хөлсөнд 799.3 мянган төгрөг, АА нийгэмлэгийн менежерт ОУ-ын чуулга уулзалтад оролцоход дэмжлэг үзүүлж онгоцны тийзний үнэ 1.2 сая төгрөгийг тус тус ГХУС зардлаас гаргасан байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн тогтоолоор байгууллагуудад фото аппарат, видео камер, сандал ширээ, принтерийн хор, бичгийн цаасны үнэ 4388.0 мянган төгрөг шилжүүлснийг хүснэгт № 8-д харуулав.

Хүснэгт №8		мянган төгрөгөөр	
	Хөрөнгө		Бичиг хэргийн зардал
Прокурорын газар	Видео камер	990.0	200.0
Тагнуулын газар			150.0
Мэргэжлийн хяналтын газар	Зургийн аппарат	998.0	150.0
Шүүх			150.0
Хүүхэд гэр бүл хөгжлийн газар			150.0
Цагдаагийн газар			200.0
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	Зургийн аппарат	900.0	
Өмгөөлөгчдийн зөвлөл	Ширээ, сандал	500.0	
Дүн		3388.0	1000.0

ГХУС үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлж буй хөрөнгө, ажил үйлчилгээний үнэ, өртөг, марк, тодорхойлолтыг хянаагүй, нэхэмжлэхийн дагуу төлбөр хийсэн, ГХУС тухай хуулийн 19.4-т “ГХУС ажилд зориулсан хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно” гэж заасныг хэрэгжүүлээгүй нийт 7781.2 мянган төгрөг зарцуулсан байна.

3.3.11. ГХУСҮА-нд 2015-2017 онд 172.8 сая төгрөгийг зарцуулсан ба дээрх зориулалт бус зардал нийт зардлын 4.6 хувийг эзэлж байна. Иймд энэхүү зөрчлийг дахин давтан гаргуулахгүй байх албан шаардлага бичлээ.

3.3.12. ГХУСҮА-ны зардалд тавих хяналтыг сайжруулж ГХУС үйл ажиллагааны зардлыг үр ашигтай зарцуулах, зарцуулсан хөрөнгийг үр дүнтэй ашиглах, хөрөнгө,

мөнгө шийдвэрлэгдсэн төрийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоог дээшлүүлж төсвийн хөрөнгийг үр ашигтай, үр нөлөөтэй зарцуулах хэрэгтэй байна.

3.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна.

3.4.1. МУ-ын Хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 1998 оны 88/152 тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын хяналт тавих, тайлагнахтай холбоотой заалтууд хэрэгжээгүй байна. Тухайлбал:

- ГХУС ажилд зориулан олгосон хөрөнгийн тайланг Зөвлөлөөс улирал бүр гаргаж санхүүгийн байгууллага болон дээд шатны зөвлөлд хүргүүлнэ
- Шүүх, Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас эрүүгийн гэмт хэрэгт ногдуулсан торгох ялыг шүүхийн шатанд уг этгээд биелүүлснээр төсөвт орсон орлого, шат шатны Засаг дарга, шүүгч, Цагдаагийн байгууллагаас холбогдох хууль тогтоомжид заасны дагуу торгууль ногдуулж орон нутгийн төсөвт оруулсан торгуулийн орлого, торгуулийг тухайн этгээд төлөөгүй тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар албадан гаргуулсны орлого зэргийг холбогдох байгууллагууд улирал тутам гарган ирүүлэх
- ГХУС арга хэмжээний зохион байгуулалт, зарцуулалтад тухайн шатны Хурал, санхүүгийн хяналт шалгалтын байгууллага хяналт тавина. ГХУС ажилд зориулсан хөрөнгийг зориулалт бус зүйлд зарцуулсан албан тушаалтанд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

3.4.3. ОНЦ нарт урамшуулал олгох үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.

- АИТХ-аас жил бүр сумдад ажиллах ОНЦ-г 23 орон тоогоор баталсан бөгөөд 2015 онд 22, 2016 онд 12, 2017 онд 21 хүн ажилласан байна. Цагдаагийн газраас сумдын ОНЦ-г өөрчлөн ажилд томилох, ажлаас чөлөөлсөн тушаалыг тухай бүр ИТХ-ын нягтлан бодогчид ирүүлээгүй байна. Сумаас ирүүлсэн нэхэмжлэлийг үндэслэн урамшууллыг сумын ЗДТГ-т шилжүүлдэг бөгөөд сарын дундуур чөлөөлөгдөх, ажилд томилох тохиолдолд урамшууллын санхүүжилтийг бүтэн олгож байна.

3.4.4. ГХУС үйл ажиллагаанд олгосон хөрөнгийн зарцуулалт, үнэлгээ, анхан шатны бүртгэл хөтлөлт, тайлагналд тавих хяналт хангалтгүй байна.

- Эд хариуцагч тухайн цаг хугацаанд тайланг үнэн зөв гаргаагүй, шатахууны зарцуулалтын баримтанд жолоочийн тооцооны хуудас, шатахуун олгосон шаардах хуудас дутуу, холбогдох баримт материалыг бүрэн архивлаагүй анхан шатны хоосон маягт хавсаргасан, нягтлан бодогч түүнийг хянаагүй байв.
- Нягтлан бодогч сумдын ГХУС салбар зөвлөл болон байгууллагуудад олгосон санхүүжилтийн гүйцэтгэл, тайланг аваагүйгээс тухайн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд тавих хяналт орхигдож байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

ХСБ-ууд гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцлийг тогтоож, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг арилгуулж ажилласан байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд тулгарч буй зарим асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

ИТХ гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгах талаар ААНБ-аас зохиож байгаа ажлыг хэлэлцэж чиглэл өгөх, хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр ажиллуулах хүний тоо, урамшууллын хэмжээг шийдвэрлээгүй байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-д хуульд заасан ГХУС чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналтад байгаа хүний талаарх цахим мэдээллийн санд шүүгчийн захирамж, хэргийн дугаар байдаггүй байна.

Төсөв санхүүгийн хүрэлцээгүйгээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуульд заасан зарим арга хэлбэрийг орон нутагт хэрэгжүүлэхгүй байна.

Салбар зөвлөл нь гэмт хэргийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт хийж байгаа хэдий ч шалтгаан нөхцлийг арилгуулах чиглэлээр хийсэн арга хэмжээ хангалтгүй байна. Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй хүүхэд залуучуудын судалгаа байхгүй байна.

Монгол улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан СЗ хариуцан ажиллах зарим арга хэмжээг аймгийн СЗ-ийн 2017 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлын төсвийг бодитой тооцож төлөвлөөгүй, сангийн яам, аймгийн ИТХ-аас өмнөх жилийн гүйцэтгэлийг үндэслэн төсөв хянаж баталсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, холбогдох журмын төсөв, санхүүжилттэй холбоотой заалтууд нь Төсвийн тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулиудтай нийцэхгүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төсвөөс байгууллагуудад үндсэн хөрөнгө, принтерийн хор, цаас авч өгөх, хууль эрхзүйн сургалт, сурталчилгаа явуулахад хоолны зардал гаргах зэргээр зориулалт бус зардал гаргасан байна.

ГХУС үйл ажиллагаанд олгосон хөрөнгийн зарцуулалт, анхан шатны бүртгэл хөтлөлт, тайлагналд тавих хяналт хангалтгүй байна.

Аудитаар нийт 16.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж 7.8 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 8.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХ-ын дарга С. Түмэнбаяр танаа:

1. Гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцлийг арилгах талаар ААНБ-аас зохиож байгаа ажлыг хэлэлцэн чиглэл өгөх,
2. Хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр ажиллуулах хүний тоо, урамшууллын хэмжээг тогтоох талаар хэлэлцэх.

ГХУСАЗСЗ-ийн дарга С.Түмэнбаяр танаа:

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг арилгуулахад тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлүүлэх.
2. Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй хүүхэд залуучуудын судалгаа гаргуулах, тэдний зан үйлийг өөрчлөх, сургалт сурталчилгаа зохион байгуулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх
3. Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан салбар зөвлөл хариуцан ажиллах арга хэмжээг аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2017 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх
4. ГХУС тухай хуулийн 19.1 дэх заалтыг Төсвийн тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулийн холбогдох заалтуудад нийцүүлэн өөрчлүүлэх тухай саналыг дээд шатны байгууллагад хүргүүлэх

ИТХ-ын нарийн бичгийн дарга Н.Хонгорзул танаа:

1. Гэмт хэрэг гарах шалтгаан нөхцлийг судалсан судалгааг үндэслэн тухайн жилд салбар зөвлөлөөс зохион байгуулах ажил тус бүрт ГХУС үйл ажиллагааны зардлыг оновчтой, бодитой тооцож төсвийн санал хүргүүлж байх
2. ГХУСҮА-ны зардлыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналтаа сайжруулж ажиллах
3. ГХУСҮА-ны төсвөөс санхүүжүүлсэн ажил гүйлгээнд хяналт тавьж холбогдох байгууллагуудаас хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг нотлох баримт материалыг хүлээн авч ажиллах

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч. АРИУНАА

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Утас/факс: (705) 2-31-40

2017. 10. 23 № 288
танай 2017. 10 -ны № 1-639 -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ч.АРИУНАА ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн Үндэсний Аудитын газрын 2017 оны аудитын ажлын төлөвлөгөөний дагуу хийсэн “Хууль сахиулах байгууллагуудын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Манай байгууллагын зүгээс аудитын явцад тайлбар өгөн хамтран ажилласан бөгөөд тайланд тусгагдсан дүгнэлт, зөвлөмжийг хүлээн зөвшөөрч цаашид анхаарах зүйлээ тодорхойлж байна.

Тайланд аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс дараах зүйлүүдийг тодруулж тусгах саналтай байна.

Үүнд:

1. Тайлангийн 1.2.5-д “Тус аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй хүүхэд залуучуудын судалгааг гарган, тэдний зан үйлийг нөлөөлөх сургалт сурталчилгаа зохион байгуулах ажил орон нутагт хийгдэж байгаагүй.” гэсэн байна.

Гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй хүүхдүүдэд чиглэсэн холбогдох сургалт сурталчилгааны ажил, арга хэмжээний талаар аймгийн Цагдаагийн газраас дахин тодруулах шаардлагатай байна. Хэдийгээр энэхүү судалгаа байгаагүй ч энэхүү ажил тодорхой хэмжээнд хийгдсэн гэж үзэж байна.

2. Тайлангийн 3.1.7. ГХУСҮА-ны зардлыг бодитой төлөвлөж, батлаагүйгээс Цагдаагийн байгууллагын ГХУС үйл ажиллагаанд шаардлагатай техник хэрэгсэл авах, ажлын байрны өртөгийн засвар, тавилга, эд хогшил авах, замын хөдөлгөөний мэдлэг олгох тэмцээнд зориулсан хөрөнгийг бусад эх үүсвэрээс шийдвэрлэсэн байна.

Энэхүү техник хэрэгсэл авах, ажлын байрны өргөтгөлийн засвар, тавилга, эд хогшил авахад зориулсан хөрөнгийг тухайн байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагч буюу Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад тусгах зарлад гэж

0000012

Төсвийн тухай хуулийн агуулгаар Сангийн яам үзэж төсвөө хянадаг. Төсвийн тухай хуультай Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон түүнд холбогдон гарсан журам нь зөрчилдөж байгаатай холбоотой гэж үзэж байна. Түүнчлэн ирэх оны төсвийн төслийг боловсруулахад аймгийн ИТХ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлаа өөрсдийн хэмжээнд ирэх онд хийх ажил, хэрэгжүүлэх зайлшгүй зардал гэж тооцон тодорхой хөрөнгийг төсөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргэдэг. Харин сангийн яамнаас хянаж, аймгийн ИТХ-аас батлагдсан төсвийн хүрээнд ирэх оныхоо ажлыг нарийвчлан төлөвлөж тусгадаг. Төсвийн хуулийн дагуу ийнхүү төсвөө төлөвлөж байгааг бодьтой төлөвлөөгүй гэж үзэхэд бас учир дутагдалтай харагдаж байна.

3. Тайлангийн 3.3.10. *Зориулалт бусаар зарцуулсан байдал* "... 2017 онд Дэлхийн эмч нарын өдөрт зориулсан сургалтын зардал 130000 төгрөг зарцуулсан..." гэж андуурч, зөрүүтэй тусгагдсан байгааг засварлах хэрэгтэй байна. Аймгийн ГХУСАЗСЗ-өөс 2017 онд ийм зардал гаргаагүй бөгөөд 2017.03.10-ны өдрийн ГХУСАЗСЗ-ийн 02 тоот тогтоолоор "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль сурталчлах сургалт"-ын зардалд шаардагдах 490000 төгрөгийг баталсан ба үүнээс хоол, буудлын зардалд 130000 төгрөг зарцуулсаныг ийнхүү ташаа тусгасан байна.

Мөн орон нутагт хууль эрх зүйн чиглэлээр үзлэг, шалгалт, сургалт сурталчилгаа хийхэд хоолны зардал, сумдын иргэдтэй уулзах өдөрлөг, арга хэмжээний тээврийн зардалд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төсвөөс мөнгө олгосон нь зориулалтын бусаар зарцуулсан гэж тайланд тусгагдсан байна. Гэтэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн хэлбэр болох хууль эрх зүйн сургалт, сурталчилгааг хийхэд зүй ёсоор гардаг зардал нь тухайн сургалтын сургагч багшийн хөлс, томилолт, буудал, хоолны мөнгө гэх мэт зардал байдаг. Үүнд өөр зардал гаргах шаардлагагүй байдаг. /сургалт, сурталчилгааны материал, гарын авлага хэвлэх нь үүнээс тусдаа зардлаар төлөвлөгддөг/ Сумдын иргэд, төрийн албан хаагчидтай уулзах, хяналт шалгалт хийх, сургалт сурталчилгаа зохион байгуулахад мөн л шатахууны болон томилолтын зардлаас өөр гарах зардал байдаггүй. Энэхүү зардлыг төсвийн өөр зүйл ангиас гаргах боломжгүй бөгөөд аймгийн ИТХТ-ийн 2016 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 2.12 дахь хэсэгт заасны дагуу зөвлөлийн үйл ажиллагааны зардалд зарцуулсан болно. Иймд эдгээр зардлуудыг зориулалтын бусаар зарцуулсан гэж үзэхгүй байгааг тайланд тусгаж өгнө үү.

НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



Н.ХОНГОРЗУЛ



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,

Утас/факс: (705) 2-25-33

E-mail: dornogobi_mgl@yahoo.com

2017.10.23 № 2/1897
танай 2017.10.20-ны № 1-6/640-т

**АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Ч.АРИУНАА ТАНАА**

Танай байгууллагаас ирүүлсэн 2017.10.20-ны өдрийн 1-6/640 дугаартай албан бичигтэй танилцлаа.

Тус тайлангийн дүгнэлт нь “Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргээ хэрэгжүүлж байгаа ч гэмт хэргийн гаралт буурахгүй байна” гэжээ. Гэтэл гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа шалтгаан нөхцөл нь иргэд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан зарим эрх, үүргээ хэрэгжүүлдэггүй, иргэдийн санамсар болгоомжгүй, сонор сэрэмж муу байдагтай холбоотой байна.

Иймд иргэд хуульд заасан эрх, үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгаагаас шалтгаалж гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа талаар тус дүгнэлтэд тусгуулах саналыг хүргүүлж байна.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Г.ЭРДЭНЭЦЭЦЭГ

02 1242



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА ТАНАА

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ПРОКУРОРЫН ГАЗАР**

44107 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Утас/Факс: (705) 2-25-09
E-mail: dornogovi@prokuror.mn

2017.10.23 № 1695
танай 2017.10.20 -ны № 1-6/642 -т

**Аудитын гүйцэтгэлийн тайланд
санал хүргүүлэх тухай**

Тус аймаг дахь Төрийн аудитын газраас "Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн"-гийн талаар хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцаад дараах саналыг гаргаж байна. Саналыг тайлангийн дугаарын дагуу нэгтгэж бичлээ. Үүнд:

1.1.2. Тус аймгийн прокурорын газраас аймгийн хэмжээнд сүүлийн 3 жилийн хугацаанд зонхилон үйлдэгдэж буй "Хүний амь, бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, "Бусдын эд хөрөнгийг хулгайлах", "Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн" гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судалж, үүний мөрөөр орон нутгийн төр захиргаа болон хуулийн байгууллагуудтай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шат дараатай зохион байгуулсан боловч тайлангийн 1.1.7-д заасан шалтгаанууд нөлөөлсөний улмаас гэмт хэргийн гаралт төдийлөн буураагүй гэж дүгнэхээр байна.

1.1.4.Прокурорын мэдэгдэл хүлээн авсан аж ахуйн нэгж байгууллагууд нь тодорхой ажлуудыг зохион байгуулаад хариуг буцаан хүргүүлэхдээ хуулийн хугацаа хэтрүүлсэн нь баяр, амралтын өдөр таарсан, түүнчлэн зарим аж ахуйн нэгжүүд нь мэдэгдэл хүлээн аваад нүүгээд явдаг, үйл ажиллагаагаа зогсоодог, байгууллага, аж ахуйн нэгж удирдаж буй албан тушаалтнуудын хуулийн талаарх мэдлэг хангалтгүй, хөдөөгийн сумдууд нь шуудангаар хүлээн авсан үеэс хуулийн хугацаа тоолдог зэрэг шалтгаанууд нөлөөлжээ.

3.3.Прокурорын байгууллагад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах төсөв байдаггүй ба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах төсөв байх зайлшгүй шаардлага байгааг энэ шалгалтын дүнгээр уламжилж өгнө үү.

АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОР, ХУУЛЬЦААЗЫН
ИТГЭМЖИТ ЗӨВЛӨХ

С.ЦЭРЭНСАМБУУ

0000212

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн ирүүлсэн саналд:

1. Цагдаагийн газраас ирүүлсэн 2015-2017 оны эхний хагас жилийн тайлан, мэдээнд гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй хүүхдүүдэд чиглэсэн сургалт сурталчилгааны ажил хийгдсэн талаар байхгүй байна. Тус газрын ажил хариуцсан холбогдох албан тушаалтнаас энэ чиглэлд тусгайлан сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулаагүй гэсэн тайлбарыг өгсөн болно. Иймд тайлангийн дүнгийн хэсэгт өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.
2. Аудитын дүнгийн 3.3 дахь хэсэгт болон Хүснэгт №7-гийн зориулалт бусаар зарцуулсан тоон мэдээлэлд 0.1 сая төгрөгийг хасч өөрчлөлт орууллаа.

Аймгийн Засаг даргаас ирүүлсэн саналд:

1. Саналыг хүлээн авч аудитын дүнгийн 1.1.9-д “Гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа нь иргэд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан зарим эрх, үүргээ хэрэгжүүлдэггүй, иргэдийн санамсар болгоомжгүй, сонор сэрэмж муу байдагтай холбоотой байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ, хуулийн этгээд хуульд заасан зарим эрх, үүргээ хэрэгжүүлдэггүй, ажилтнууддаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах ажил хангалтгүй байна” гэж нэмж, найруулан тусгасан болно.

Аймгийн Прокурорын газраас ирүүлсэн саналд:

1. Аудитын дүнгийн 1.1.2, 1.1.7-д ирүүлсэн саналыг хүлээн авч 1.1.8-д “Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судалж, орон нутгийн төр захиргааны байгууллагуудтай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шат дараатай зохион байгуулсан боловч дээрх шалтгаанууд нөлөөлсөний улмаас гэмт хэргийн гаралт төдийлөн буурахгүй байна” гэж нэмж тусгав.
2. Аудитын дүнгийн 1.1.4-д ирүүлсэн санал нь нэмэлт тайлбар тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :

Ахлах аудитор
Аудитор

Ц.Лүндэгмаа
П.Энхбаяр

ХЯНАСАН:

Аудитын менежер
Дарга, Тэргүүлэх аудитор

Ч.Хэрлэнчимэг
Ч.Ариунаа

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.